

РОЛБИЙДОРЖИЙН “ЖАНЖАА ХУТАГТ” ХЭМЭЭХ ХУВИЛГААН ЦОЛНЫ УЧИР ШАЛТГААНЫ ТУХАЙ

Б.Сайнбилэг (Доктор PhD)
ШУА.Философийн хүрээлэн

Түлхүүр үгс: Жанжаа, хутагт, Дагва-Одсэр, Агваанлуvsан, Ролбийдорж, хувилгаан цол, алдаршсан нэр, тодотгол нэр.

Товч утга: Буддизмын түүхэнд чухал үүрэг гүйцэтгэсэн зарим нэгэн эрдэмтэн лам нарын тухай эрдэм шинжилгээний болон эрдэм шинжилгээний бус өгүүлэлд тэдгээрийн алдар цол, зэрэг дэв, дүрүүдийн тухай олон янзаар бичдэг бөгөөд ялангуяа хувилгаан дүрүүдийг дугаарлан бичихдээ эрс зөрүүтэй бичдэг хандлага ажиглагдаж байдаг. Үүний нэг жишээ болсон Жанжаа Хутагт Ролбийдоржийн хувилгаан цолны дэс дугаарыг зөрүүтэй бичдэг байдалд тодруулга хийх зайлшгүй шаардлагатай байгаа юм. Учир нь аливаа түүхэн бие хүмүүсийн алдар цол бүр өөрийн гэсэн түүхтэй тухайн үг тэмдэглэгээ нь гарал үүсэлтэй тул эрдэм шинжилгээний судалгаагаар үндэслэлтэй бичиж хэвших шаардлагатай байгаа билээ. Тиймээс “Жанжаа” хэмээн алдаршсан түүхэн гурван бие хүмүүсийн өмнөх дүрүүдийн үе залгамж, өргөмжлөгдсөн нэр цолны учир шалтгааныг эх сурвалжаас хөөн судалж логик үндэслэлтэй гаргалгаа гаргахыг хичээлээ.

* * * * *

Буддын уламжлалд хутагт, хувилгаад болон дээд лам нар маш олон нэр цолтой байдаг бөгөөд зарим тохиолдолд түүнийг андуурах, зөрүүтэй бичих зэрэг алдаа гардаг. Жанжаа хутагт Ролбийдоржийг барууны судлаачид бичихдээ “*second reincarnation of Changkya Qutuytu*” эсвэл “*third reincarnation of Changkya*” гэхчилэн ялгаа зөрүүтэй бичдэг. Бас дотоодын судлаачид ч ялгаа зөрүүтэй бичдэг юм байна. Зарим нь бүр “5-р дүрийн Жанжаа хутагт Ролбийдорж” ч гэж бичиж байна. Энэ олон жишээнүүдийг бид наад захын интернэтэд оруулсан мэдээ баримтуудаас эхлээд л харж болно. Ингэж дураараа бичиж болох уу? гэдэг асуудал гарч ирэх юм. Тиймээс үүнийг яаж бичвэл зохистой болох талаар эрдэм шинжилгээний үндэстэй дүгнэлт өгөх зайлшгүй шаардлагатай юм. Бидний ярьж хэвшсэн дэс тоогоор дээд лам нарын хувилгаан дүрүүдийг дугаарлан эрэмбэлэх нь зарим тохиолдолд судлаачдын дунд ялгаа зөрүүтэй байдлаас тэдгээрийг нэг мөр болгох тайлбарыг зайлшгүй хийх шаардлагатай юм. Тиймээс тэдгээр ялгаатай хандлагад хариулт өгөх зорилгоор Ролбийдоржийн “Жанжаа хутагт” хэмээх тодотгол нэрний (хувилгаан цол) учир шалтгааныг хөөн тайлбарлая.

Ролбийдоржийн өмнөх дүрүүдийн тухай: Жанжаа Хутагт Ролбийдоржийн (1717-1786) хувилгаан цолны учир шалтгааныг дэлгэрүүлж үзэхийн тулд “Жанжаа” хэмээх цолтой түүний урьд дүрийн хувилгаан лам нарыг түүхийн сурвалж бичгүүдэд хэрхэн тэмдэглэгдэж үлдсэн байдлыг үзье. Сүмбэ Хамба Ишбалжир (1704-1788) Галбарвасан мод (*dPag-bsam-ljon-bzang*) хэмээх зохиолдоо:

“[Цагаан морин жил 1630 онд] Гонлунгийн ширээнд Жанжаа цорж Дагва-Одсэр (*Grags-pa-'od-zer*) суувай.¹ [Шар луу жил 1688 онд] Гонлунгийн ширээнд Жанжаа гүүш Агваанлуvsанчойнданбалсанпо (*Ngag-dbang-blo-bzang-chos-ldan-dpal-bzang-po*) [цаашид

¹ *Sümbe qambo Isibaljor-un burqan-u šasin-u teüke. Öbör Mongyol-un arad-un keblel-ün qoriy-a.*, 1993. хуудас 622

Агваанлувсан]суувай.²[Улаагчин тахиай жил 1717]Жанжаагийн хувилгаан Ишданбийдонмэ³[төрсөн].” гэж бичжээ.

Түүнээс гадна *Галбарвасан мод* хэмээх зохиолдоо Сүмбэ Хамба Ишбалжир нь Жанжаа Дагва-Одсэрийг “марин равжамба” эсвэл “цорж” мөн Жанжаа Агваанлувсанг “ринбоче”⁴ хэмээн цоллон бичсэн тохиолдол бас байна. Сүмбэ Хамбын бичсэнээс үзвэл тэрээр “Жанжаа” хэмээх тодотгол нэрийг дэс тоогоор дугаарлан бичсэнгүй мөн “Хутагт” хэмээн ялган тодотгоогүй байна. Миний ажигласнаар эртний эрдэмтэн лам нар зохиол бүтээлээ туурвихдаа хувилгаан дүрийн дээд лам нарын нэрийг дэс тоогоор нэгдүгээр, хоёрдугаар гэх мэт дугаарлан бичдэг тогтсон уламжлалтай байгаагүй юм. Тиймээс орчин үеийн судлаачдын бичиглэлд байдаг дугаарлах үзэгдлийг тайлбарлахдаа тухайн бие хүнтэй холбоотой асуудлууд болон түүхэн нөхцөл байдлыг хамтад нь судлаж бодтой хариулт өгөх нь чухал юм. Тиймээс Ролбийдоржийн “Жанжаа Хутагт” хэмээх хувилгаан цолны учир шалтгаанд үндэслэлтэй хариулт өгөхийн тулд түүхэн нөхцөл байдлыг зайлшгүй судлаж үзэх шаардлагатай. Энэ өгүүлэлд “тодотгол нэр”, “алдаршсан нэр”, “хувилгаан цол” хэмээх гурван хэллэг нь утга ойролцоогоор хэрэглэгдэх юм. Харин “Хувилгаан цол” хэмээх нь дээд ламын хувилгаан дүрүүдэд давтагдан нэрлэгддэг алдар цолыг ялган тодорхойлох байдлаар хэрэглэлээ. Жишээлбэл, “Жанжаа” гэдэг нь Дагва-Одсэрийн дараагийн дүрүүдыг Жанжаа ламын хувилгаан болохыг нотлох байдлаар дагалдах болсон тул “хувилгаан цол” хэмээн онцлон бичлээ.

Хамгийг айлдагч Гончигжигмэдвампогийн (1728-1791, dKon-mchog-‘jigs-med-dbang-po) зохиосон Дээд лам хамгийг айлдагч Жанжаа Ролбийдоржийн үе дамжлагын эрхис үгст өгүүлсэн гайхмашигт сүжгийн мод хэмээх оршвой.⁵ [цаашид *Жанжаа Ролбийдоржийн үе дамжлагын эрхис*] хэмээх зохиолд түүнээс өмнөх үеийн арван дөрвөн үеийн хувилгаан дүрүүдийг бичиж тэмдэглэсэн байдаг.

1. Зунда (*Tsun da*) [дээрх сурвалжид: 5a]
2. Шакьяапа (*Shākyapa*) [5b]
3. Азарьяа (*Ātsarya*) [6a]
4. Гава Балцэг (*Kaba- dpal- brtsegs*) [6b]
5. Допрагва (*Sgro- phrag- pa*) [7a]
6. Сисирива (*Si- sir i- pa*) [8b]
7. Ланританва (*Glang- ri- tang- pa*) [9a]
8. Дови-онпа Чойжал пагва (‘*Gro- ba’i- mgon- pa chos- rgyal- ‘phags- pa*) [11a]
9. Содномжалцан (*bSod- nams- rgyal- mtshan*) [22b]
10. Жамчэнчойжи (*Byams- chen- chos- rje*) [35 a]
11. Жавзанчойжигжалцан (*rJe-btsun- chos- kyi- rgyal- mtshan*) [40b]
12. Гондэнчойжи (‘*khon- sten- chos- rje*) [60b]
13. Жанжаа Дагва-Одсэр (*ICang skya grags- pa ‘od zer*) [85b]
14. Жанжаа Агваанлувсанчойдан (*ICang skya ngag- dbang- blo- bzang- chos- ldan*) [87b]
15. Жанжаа Ролбийдорж (*ICang skya rol- pa’i- rdo- rje*) [121a]

² Мөн тэнд, хуудас 631

³ Ишданбийдонмэ (*Ye-shes-bstan-pa’i-sgron-me*) нь 1735 онд Ролбийдоржийн Лувсан- Ишбалсанногоос гэгцэл санваар хүртэхдээ авсан сахилын нэр юм. (Dag yig mkhas pa’i ‘byung gnas, *Цбыр Mongyol-un arad-un ke-blel-yn qoriy-a.*, 2002, х 4)

Түүнээс гадна Жанжаа хутагт Ролбийдоржийг “Дишири”, “Лалитабазар” гэх мэтчилэн цоллон дуудах тохиолдлууд байдаг.

⁴ *Icang skya rin po che ngag dbang chos ldan dang ‘jam dbyangs bzhad pa yab sras gnyis ni... Iclang skya ma ring rab ‘byams pa grags pa ‘od zer gyi brul sku sde...* (Sarat Chandra Das. *Pag sam jon zang*. Calcutta: The presidency jail press., 1908. p 354)

⁵ *rje btsun bla ma thams cad mkhyen pa Iclang skya rol pa’i rdo rje’i ‘khrungs rab(s) kyi phreng ba gnam du brjod pa ngo mtshar dad pa’i ljon shing zhes bya ba*

Гончигжигмэдвампо нь энэхүү бүтээлдээ Ролбийдоржоос өмнөх 14 хувилгаан дүрүүдийн намтарыг товч өгүүлсэн байна. Дээрхи 15 хувилгаан төрлүүдийн эхний 3 нь Энэтхэг орноо төрж, дараагийн 11 нь Түвд орноо төрж 15 дахь буюу Ролбийдоржийг Монгол гарлын хүн хэмээн тэмдэглэсэн байна. Түүнээс гадна 8 дахь хувилгаан дүр нь Их Юань улсын багш Пагва лам (1235-1280) байсан байна.⁶ Эдгээр хувилгаан дүрүүдийн уламжлагдах шалтгаан болсон анхны дүрийг Зунда гэх бөгөөд тэрээр агуу их шид бүтээлээр ертөнцөд хувиран төрөх болсон учир шалтгааныг ийнхүү тайлбарлан өгүүлжээ:

“[Тэрээр ийн хэмээн сонссон болой] Үе дамжлагын соёрхол тавьсан танаа, энэ газар амгалан заларсан нарны садан амьтан бүхний цог итгэл болохын цагт, их хөлгөний хутагт дээд туулсан архадын ёсыг сайтар барьсан Зунда дор соёрхлыг тавья...хэмээн номлосон мэт. Бидний багш чадагч Шакьяа ертөнцөд заларсан цагт их богд энэ архад Зунда хэмээгч төрсөн бөгөөд ид залуу хотол чуулган төгсөж гэрээ орхин гарч, үзүүлэхийн нүдний ид увьдас сонсохуйд шүтсэнээр архадын үрийг олсон болой. Өгүүлэхүй тийн ариуссан агаараас хаан, бярман хийгээд гэрийн эздэд ертөнцөөс магад гарахын үгсийг бүтээж тонилохуй мөрд зохиох тэргүүтнээр тийн тонилохуйн эцэст хүрсэн болой. Одод дундах гойд гэрэлтэй нь (сэргэг) хийгээд моддын дундах зандан нь мэт чадагчийн шавь сонсогчдын дунд та эрдмийн чуулганаар үзэсгэлэнтэй. Билиг билгүүний илдээр гурван орны хотол барилдлагын дайсныг номхотгох арганд мэргэн тэр үүнийг оносноор ороонго модны анхны нахиа эх сурвалж болсон.”⁷ хэмээжээ.

Дээр дурдсан хэсгийн агуулгыг үзвээс гэгээрсэн архад Зунда өөрийн хураасан сайн буяны үрээр дараагийн төрлүүддээ эрдмээр төгссөн оюунаа хувилах агуу их шид бүтээлийн эх сурвалж буюу үргэлжлэлийн шалтгаан болсон. Түүний үндсэн дээр Зунда нь дараа дараагийн дүрүүдэд хувиран төрсөн бөгөөд Ролбийдорж нь 15 дахь хувилгаан дүр болохын уг шалтгааныг үзүүлжээ.

Энэ 15 хувилгаан дүрүүдээс сүүлийн 3 хувилгаан дүр (13, 14, 15 дахь) нь “Жанжаа” гэсэн тодотгол нэрийг авсан байна. Хамгийн анхны “Жанжаа” болох Дагва-Одсэр нь хэрхэн тэрхүү тодотгол нэрээр хэрхэн алдарших болсныг шинжилж үзье.

“Жанжаа” хэмээх нь Дагва-Одсэрийн мэндэлсэн Амдо нутгийн Зонха хэмээх газарт харьяалагдах жижиг тосгоны нэр⁸ юм. Тиймээс Дагва-Одсэрийн алдаршсан нэрийг газар нутгийн нэр (*toponym*) хэмээн хэлэх бүрэн үндэслэлтэй юм. Тэрээр ард олны дунд “Жанжаа нутгийн лам” хэмээн алдаршиж, түүнээс хойш “Жанжаа Дагва-Одсэр” хэмээн олонд танигдан алдаршиж өөрийн нэрийн урд тодотголтой болсон байх нь.

Буддизмын уламжлалд дээд лам нарыг алдаршуулах нэр нь тухайн түүхэн хүмүүсийн төрсөн газар байх нь цөөнгүй байдаг. Жишээлбэл, Богд Зонхов (*bLo-bzang-grags-pa*, 1357-1419) өөрийн төрсөн газар болох Зонха (*Tshong-kha*) хэмээх нэрээр алдаршсан билээ. Мөн дээд лам нар өөрийн үндэсний овог аймгийн нэрээр ч алдаршсан тохиолдлууд байдаг бөгөөд үүний жишээ нь, Тууган гэгээний анхны дүр Лувсанравдан (*Tu'u bkwan bLo-bzang-rab-brtan*, 17 зууны эхэн үед амьдарч байсан) Хөхнуурын Тууган овогт мэндэлсэн бөгөөд “Тууган

⁶ Мөн тэнд [22b]

⁷ | *de yang 'di skad ces thos te* | *'khrungs rabs gsol 'debs las khyod ni zhing 'dir bde gshegs nyi ma'i gnyen* | *'gro ba kun gyi dpal du gyur ba'i tshes* | *theg chen 'phags mchog nyan thos dgra bcom tshul* | *rab bzung tsun dar gyur la gsol ba 'debs* | *zhes gsungs pa ltar* | *bdag cag gi ston pa shākya thub pa 'jig rten du byon pa'i tshes bdag nyid chen po 'di dgra bcom pa tsun da zhes bya bar sku'i skye ba bzhes te* | *de ni gzugs dang lang tsho phun sum tshogs shing khyim nas khyim med par rab tu byung ste* | *ston pa'i spyen sngar gdams ngag nyan pa la brten nas dgra bcom pa'i 'bras bu thob ste* | *brjod pa rnam par dag pa'i dbyangs kyis rgyal po dang* | *bram ze dang* | *khyim bdag rnam la 'khor ba las nges par 'byung ba'i gtam mdzad de thar ba'i lam du bkod pa sogs rnam par thar pa mtha' yas pa dang ldan pa zhig go* | | *rgyu skar dbus na bsang ba dang* | *rkang 'thung khrod na tsan dan bzhin* | *thub pa'i slob ma gsung skyes dbus* | *khyod ni yon tan tshogs kyis mdzes* | *ye shes ral gris kham gsum gyi* | *kun sbyor 'dul ba'i dgra thabs mkhan* | *'di de rtogs brjod 'khor shing gi* | *me thog rab 'thon dang po yin* | [5a]

⁸ | *mdo smad btsong kha'i yul gyi hu lan nu ra zhes pa'i lung pa'i mdor nye bar* | *lcang skyā zer ba'i grong tsho che chung 'tsham pa zhig yod pa der sku skyes ba zhes* | [105b, 106a]

овгийн Лувсанравдан” хэмээн алдаршиж “Тууган” хэмээх тодотгол нэр түүний дараагийн төрлүүдэд уламжлагдах болсон. Иймэрхүү тохиолдлууд Буддизмын уламжлалд түгээмэл ажиглагддаг бөгөөд орчин үеийн судалгаанд нэрүүдийн гарал үүслийг судлаж, овог удамтай холбоотой нэрүүдийг овог гарвалын нэр (*cognomen*) гэж томъёолоод байгаа. Нөгөө талаас төрсөн газар оронтой холбоотой нэрийг (*toponym*) гэж томъёолон дээд лам нарын алдаршсан нэрүүдийг эрдэм шинжилгээний судалгаанд зааглан ялган бичиж байгаа.

Дээр дурдсан уламжлалаас үүдэлтэй Дагва-Одсэр нь “Жанжаа” хэмээх орон нутгийн нэрээр овоглон түүхэн сурвалж бичгүүдэд тэмдэглэгдэн үлдсэн байна. Буддын дээд хувилгаан лам нар маш олон нэр цолтой, алдартай байдаг учраас бид тэдгээрийг ялган тэмдэглэх нь зүйтэй юм. “Жанжаа” гэдэг олонд алдаршсан нэрийг тухайн бие хүмүүсийн шашны болон төрийн дээд тушаалтан хүмүүсээс олгогдсон “өргөмжлөлт нэр”, “хэргэм цол буюу мяндаг тушаал” зэргээс ялган ойлгох хэрэгтэй.

Дараагийн хувилгаан дүр бол Агваанлуvsан бөгөөд мөн тэрээр “Жанжаа” хэмээн алдаршсан юм. Гончигжигмэдвапогийн бичсэнээс үзвэл Агваанлуvsан хэрхэн тэрхүү алдрыг уламжлах болсон нь логикийн хувьд ойлгомжтой болж байгаа юм. Дагва-Одсэрийн “Жанжаа” хэмээх алдрыг уламжлах болсон шалтгаан нь Агваанлуvsанг хойд дүр нь болгож тодруулсан үйл явцтай салшгүй холбоотой байна. Энэхүү үйл явдлыг хэрхэн тэмдэглэснийг үзвэл:

[Тэрээр] усан морин жилийн арван нэгдүгээр сарын арав дахь өдөр эцэг эх хоёртоо хүү нь болж мэндэлсэн. Хэвлийд оршихын цагт эхийн зүүдэнд нарны хот мандал газраас олдов тэргүүтэн гайхамшигтай зөн олон гарсан. Тэндээс зохилдох зүйлсийн баяр хурим үргэлжилж бага насандаа урьдын орноо даган дурсаж, би жанжаа лам мөн, надад лам хийгээд гурван шүтээн үүн лүгээ үйлдэх ёсны зарлигийг илэрхийгээр соёрхож талбисан... Эцэг эх хоёр лагшинг төрүүлсэн ёсыг эс сонссонд үг эс өгүүлэн, тэр үед бүү ярь хэмээн хорьсонд юу ч өгүүлэлгүй хэлгүй мэт болов. Тэндээс эцэг эх хоёр сэтгэл амгалангүй болж хэлгүй мэт байхыг [засахаар] тавиглал олныг өргөвч тусыг эс олсонд бие цөхөрч убаши болгохын тэмдэг болгож Гэндэнжав [хуврагт авралыг одуулья] хэмээн нэрийдснээр ярьж чаддаг болсон байна...⁹

Тэндээс Жанжаа ламын багш тэргүүтний сонссоноор дээд ламын эд зүйлсээс заримыг нь таниулсанд эндүүрэлгүй танин барьсанд, Панчен ринбочед айлтгаж цорж Дагва-Одсэрийн хувилгаан бие эндүүрэлгүй мөн болохыг зарлигдан тогтоосон.¹⁰

Дээрх агуулгаас харвал Агваанлуvsан нь Буддизмын уламжлалын дагуу Дагва-Одсэрийн хойд дүр болох нь тогтоогдож, эрх бүхий дээд тушаалын ламаар баталгаажсан байна. Буддын уламжлалд эхийн хэвлийд оршихын зөн зүүд, урьд төрлийнхөө үйлийг санан хэлсэн үгс, урьд төрөлдөө хэрэглэж байсан эд зүйлсийг танихыг гол шалгуураа болгож хойд төрлийг тодруулдаг уламжлал байдаг. Агваанлуvsангийн хэлсэн үг болох “Би Жанжаа мөн” хэмээх үг нь урьд дүрийн Дагва-Одсэрийн алдаршсан нэрийг буюу “Жанжаа” гэсэн тодотголыг уламжлахад шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн. Өөрөөр хэлбэл Агваанлуvsан нь “дараагийн Жанжаа” гэдэг утгаар тухайн үеийн дээд лам нарт хүлээн зөвшөөрөгдөж түүний алдаршсан нэрийг өөрийн нэрний тодотгол болгон “Жанжаа Агваанлуvsан” хэмээн зөвшөөрүүлсэн

⁹ | yab yum de gnyis kyi sras su chu rta mgo zla ba 'i tshes bcu 'i mtshan mo sku blta mas | lhum su zhugs pa 'i tse yum gyi mnal lam du nyi ma 'i dkyil 'khor sa nas rnyed pa sogs rmi ltas ya mtshan pa mang du byung | de nas mthun pa 'i yo byad dag gis skyid bsrings te lo kha shas lon pa na sngon gnas rjes dran gyi mthus | nga lcang skya la ma yin | [da] nga la gra pa dang rten gsum 'di dang 'di bya ba yod tshul gyi gsung gsal po gnang byad par | yab yum gnyis kyi sku skye rnams kyi gnas tshul ma gsan ching mi mkhyen par bten | de skad ma zer zhes bkag pas ci yang mi gsung ba 'i tshul mdzad de lkugs pa lta bur bzhugs | de nas yab yum gnyis thugs ma bde dang lkugs pa 'byed pa 'i thabs dang rim gro mang du byas bas cang ma phan par lus bsgyur te dge bsnyen du bsgrubs nas mtshan la dge 'dun skyabs zhes pas biags rim gyis smra thub par gyur | [87b, 88a]

¹⁰ | de nas lcang skya bla ma 'i dpon po sogs kyi thos nas bla ma gong ma 'i yo byad 'ga' zhig ngos 'dzin 'dzad bcug par ngos 'dzin 'khrul med du byung zhing | pañ chen rin po cher zhug pas chos rje grags pa 'od zer gyi sku skye 'khrul med yin tshul gyi bka' lung gsal po stsal | [88a]

байна гэдэг логик үндэслэл гарч ирж байна. Түүнээс хойш Буддын гүн ухааны болон түүхэн сурвалж бичгүүдэд түүний нэрийг тийнхүү “Жанжаа Агваанлуvsан” хэмээн тэмдэглэдэг болсон байна.

Жанжаа Агваанлуvsан нь бага наснаасаа эхлэн Буддын судар тарнийн ёсонд мэргэшиж мөн улс төрд өөрийн гэсэн нөлөө оролцоотой, олонд танигдсан шашин төрийн зүтгэлтэн байсан. Гончигжигмэвдванпогийн тэмдэглэснээс үзвэл Жанжаа Агваанлуvsан нь Манжийн Энх-Амгалан¹¹ хаантай Бээжинд уулзаж шашин төрийн асуудлаар зөвлөлдөж байсан. Мөн Зава Дамдин гавж *Алтан дэвтэр*-тээ:

“...Шинзү Энх-Амгалан хаан бээр хуврагийн аймаг олныг байгуулж, лагшин, зарлиг, тааллын шүтээн тооноос хэтэрсэнийг босгосон билээ. Ширээт их эрдэнэ Агваанлодойжамц болон Хамгийг айлдагч Жанжаа хутагт Агваанчойжижамц тэргүүтэй шалгарсан мэргэн бүтээлч олныг тус тусын орноос нь урин залж, шашныг дэлгэрүүлэн үйлдэхэд оруулсан байна.”¹²

Монгол улсын шашин төрийн хэрэг бүхэлдээ Манж улсын бодлогоор зохицуулагдах болсон тэр цагт Буддын шашныг гол хэрэглүүрээ болгож Түвд, Монголын олонд танигдсан шашны зүтгэлтнүүдийн нэр хүнд, хүч нөлөөг ашиглан засаглалаа батжуулан тогтворжуулах үйл ажиллагааг Манж хаадууд эрчимтэй явуулж байсан. Тухайн үед Энх-Амгалан хаан Монгол газар Буддын шашныг дэлгэрүүлж, сүм дуган байгуулах замаар Монгол нутагт гарч байсан бослого тэмцлийг намжаахыг хичээж байсан. Мөн тухайн үед Буддын шашин сүм хийдийн зан үйлийг Монголчуудад тохируулан нийцүүлж шинэчлэх мөн гурван шүтээнийг олноор үүсгэн дэлгэрүүлэхийг Монголын дээд лам нарт тушаан хэрэгжүүлж байсан гэж түүхэн сурвалж бичгүүдэд тэмдэглэсэн байдаг.¹³ Жанжаа Агваанлуvsан нь Монголтой холбоотой шашны шинэчлэлийг хийх, дэлгэрүүлэх үйл ажиллагаанд идэвхитэй оролцож Өвөр Монголын Харчин, Хорчин болон Ордост олон удаа айлчилан ирж байсан байна. Түүгээр ч барахгүй Халх, Ойрадтой холбоо тогтоон үйл ажиллагаагаа өргөжүүлж байсан гэдэг билээ. Тэрээр Халх Зая Бандида, Харчин Даш ван нартай дотно холбоотой байсан тухай мэдээ байдаг.¹⁴ Ийнхүү Жанжаа Агваанлуvsан нь Монгол газар шашин дэлгэрүүлэх үйлст идэвхитэй оролцож байсан тухай түүхийн сурвалж бичгүүд тэмдэглэн үлдээжээ. Эндээс үзвэл Агваанлуvsан нь Монгол түмэнд танигдаж хүндлэгдсэн нэгэн байсан гэдгийг гарцаагүй нотлож болохоор байна.

Нэгэн сонирхолтой баримтыг дурдвал Гончигжигмэвдванпо *Жанжаа Ролбийдоржийн үе дамжлагын эрхис*-т Агваанлуvsанг “Жанжаа хутагт”¹⁵ хэмээн тэмдэглэсэн байна. “Hu-thog-tu” гэдэг нь Монгол хэлний “qutuγtu” гэдэг үгийг Түвд үсгээр галиглан тэмдэглэсэн хувилбар юм.

Эрдэмтэн Рерих бичихдээ “hu-thog-tu” гэдгийг Монгол хэлнээс Түвд хэлэнд орсон үг гэж бичсэн байна.¹⁶ Тэрээр Манж хаад Түвдийн дээд лам нарт Монгол үгээр “qutuγtu”

¹¹ Яг хэдийд айлчилж байсан гэдэг нь тодохойгүй бөгөөд Манж хаадын нэр Түвд эх сурвалжуудад тодорхой бус илэрхийллээр бичигдсэн байдаг, жишээлбэл: гонма чэнпо (gong ma chen po) эсвэл жамьян гонма чэнпо (‘jam dbyangs gong ma chen po). Тиймээс тухайн цаг үеийг тооцоолон үзэж Жанжаа Агваанлуvsантай нэг цаг үед амьдарч байсан Энх-Амгалан (1661-1720 хооронд төр барьсан) гэдэг нь гарцаагүй юм.

¹² Зава Дамдин Лувсандаян. *Алтан дэвтэр* (орчуулсан С. Гантөмөр). УБ: МБШТөв Гандантэвчлэн хийдийн Эрдэм Соёлын Хүрээлэн., 2014. х 156

¹³ gong ma chen po nas | rje ‘di nyid la lhag par brtse ba ‘i dbang gis khong gi rjes la yod mi dgos par | be ‘i cing la phebs nas bsgug na cho ga zer ba ‘i bka’ ‘bebs par mi bzang zhig mang gas pa or tu sur ‘byor bas rje ‘di ‘khor dang bcas pa dga’ bde ‘i dpal la ‘khod | de nas mkhar sngon du byon | don gnyer ba mang po dge bsnyen dang | dge tshul dang | bsnyen rdzogs kyi sdom pa la bkod | ser skya mchog dman mang por ‘dod chos ci rigs gnang | dza ya paṇḍitas lta khang dang rten gsum mang po bzhangs ba la rab gnas rgyas pa mdzad | Ролбийдоржийн үе дамжлагын эрхис [104a, 107a]

¹⁴ Мөн тэнд [108a]

¹⁵ rje ‘di dbus su phebs kar zhu sna byed mi des lcam skya hu thog thus da lam sde par mjal rgyu min zer byung zhes gong ma ‘i dgongs pa dang bstun nas zhus bas thugs mnyes tsher chen po gnang | [104b]

¹⁶ XVII, XVIII зууны үед төвдийн ширээт лам, хувилгаадад монгол хэргэм цолыг манжийн хаад олгож байлаа. Төвдөд “hu-thog-tu” (монг. qutuγtu), төвдийн ‘phags-pa гэсэн утгаар гарсан байна.

хэмээн цол олгодог гэж дурдсан байгаа боловч Гончигжигмэдвапогийн зохиолд Манж хаанаас авсан цол гэж тэмдэглэгдээгүй байгаа юм. Түвд сурвалж бичигт “hu-thog-tu” гэж галигласан хувилбараар тэмдэглэгдсэн тохиолдол тийм ч түгээмэл биш учир нь энэ нь утгын хувьд Санскрит хэлний “ārya” хэмээх үг түвд хэлэнд “*phags-pa*” хэмээн орчуулагдаж улмаар Монгол хэлэнд “qutuγtu” хэмээн утгачилагдсан билээ. Манж хэлэнд ч Монгол хэлэнд хэрэглэгддэг хувилбараар “kütuktu”¹⁷ гэж тэмдэглэгддэг. Уг гарвалын хувьд “хутагт” хэмээх үг нь Уйгураас Монгол хэлний санд орж ирсэн зээлдсэн үг билээ.¹⁸ Эндээс үзвэл Агваанлуvsан нь “хутагт” хэмээн алдарших болсон нь Монгол болон Манжтай зайлшгүй холбоотой болох нь харагдаж байна.

Мөн нөгөө талаас дүгнэж үзвэл Жанжаа Агваанлуvsан нь Энх-Амгалан хааны даалгавараар Шарын шашин дэлгэрүүлэх үүрэг хүлээсэн шашин төрийн зүтгэлтэн байсан. Түүний үйл ажиллагаа Түвдээр хязгаарлагдахгүй Монгол газар нөлөөтэй болж, Монгол газар удаа дараа заларч байсан бөгөөд Монголын нэр нөлөө бүхий шашны зүтгэлтнүүдэд, ард түмэнд танигдах болсон. Тиймээс түүнийг Монголчууд болон Манжийн төрийн зүтгэлтнүүд өргөмжлөн хүндэлж “Жанжаа хутагт Агваанлуvsан” хэмээн авгайлах болсон байна. Түүнээс биш энэ нь шашны эсвэл төрийн өндөр албан тушаалтнаас соёрхогдон албан ёсоор хүлээн авсан алдар цол бус бөгөөд ялангуяа Монголчуудын хайрласан алдар цол юм хэмээн ойлгох үндэслэгээтэй юм. Мөн Түвдүүд өөрсдөө өөрсдийн шашны зүтгэлтнээ “hu-thog-tu” гэж алдаршуулахгүй бөгөөд харин түүнийг бусад улс болон өөр үндэстэнд алдаршсан нэрээр нь түүхэн сурвалжид бичин тэмдэглэсэн төдий юм.

Харин Жанжаа Агваанлуvsангийн өмнөх дүр Жанжаа Дагва-Одсэр нь Монголчуудад танигдаагүй мөн Манж хааны даалгавараар Шарын шашинг дэлгэрүүлэх зориудын үйл ажиллагаанд оролцоогүй байгаа юм. Тиймээс түүнийг “Жанжаа” хэмээх олонд алдаршсан нэрийнхээ ард “хутагт” гэдэг өргөмжилсөн алдрыг зүүж амжаагүй болов уу хэмээн үзэж байна.

Дараагийн дүр болох Ролбийдорж нь 1717 онд ланз дөрвөн аймгийн баруун лянхуан аймаг дахь бухар орны лавайн уулны ах дүү долоо хэмээх долоон уулны энгэрт одоогийн Гансу мужийн Вувей хотод Монгол язгуурын гэр бүлд төржээ. Тэрээр Агваанлуvsангийн хойд дүрээр тодорсон явдал нь Буддизмын уламжлалыг дагаж баталгаажсан үйл явц байлаа. Тууган Агваанчойжамц (Tu'u- bkwan Ngag-dbang-chos-rgya-mtsho) түүнийг Жанжаа Хутагт Агваанлуvsангийн хойд дүр хэмээн таньж тодруулсан байдаг. Түүхэн сурвалжид тэмдэглэснээр: Ролбийдорж нь хоёр настайдаа хувилгаан лам болохын шинжийг үзүүлж урьд дүрийн үйлээ санан дурсаж “би Жанжаа лам мөн миний хийд өмнө зүгт бий” хэмээн айлдсан гэдэг.¹⁹

Түүний урд насаа санан дурсаж айлдсан үг нь өмнөх үеийн дүр Агваанлуvsангийн хэлсэн үгтэй яг адил буюу “ би Жанжаа мөн” хэмээсэн нь урдах дүрийнхээ алдаршсан нэрийг уламжлан авч “Жанжаа хутагт Ролбийдорж” хэмээн алдаршихад хүргэсэн юм. Өөрөө хэлбэл Ролбийдоржийг “дараагийн Жанжаа” мөн гэдгийг хүлээн зөвшөөрөөд зогсохгүй

[Ю. Н] Перух. Төвд хэлэнд орсон монгол үг, Олон улсын монгол хэл бичгийн эрдэмтний анхдугаар их хурал., 2-дэвтэр, УБ: ШУАХ., 1961, х 277

¹⁷ ...geli gurun-i baksi janggiya kütuktu-be gaifi amilara doroi nomun hülbumbi. Sun, Penghao, Shi Yangang, and Hasichaolu. “The 1780 Quadrilingual Inscriptions in the Longxing Monastery: The Texts and Background.” In *Xiyu lishi yuyan yanjiu jikan* 西域歷史語言研究集刊 (No.8) edited by Shen Weirong, 523-34. Beijing: Science Press., 2015, p 527

¹⁸ Ц. Дамдинсүрэн. Монгол хэлэнд орсон төвд үгс, Олон улсын монгол хэл бичгийн эрдэмтний анхдугаар их хурал., 1-дэвтэр, УБ: ШУАХ., 1961, х 68

¹⁹ | rje ngag dbang blo bzang chos ldan pa'i sku'i skye bar nges pa rnyed pa'i tshul ni | dgung lo gnyis bzhes skabs nyin gcig nga bla ma lcang skya yin gsungs shing | lho phyogs la phyag mdzub kyis bstan nas pha gir dgon pa chen po yod | nga der song nas bla ma byed rgyu yin zhes sogs sngon gnas rjes dran gyi gsung mang du byon 'dug cing | (Tu'u-bkwan blo-bzang-chos-kyi-nyi-ma. lcang skya rol pa'i rdo rje'i rnam thar, хуудас 55)

Агваанлувсангийн алдаршсан “хутагт” хэмээх цолыг хамтад нь уламжилан авчээ. Тэрээр Монгол язгуурт Монгол хүн байсан тул Монголчууд түүнийг хүндлэн биширч “Жанжаа хутагт” хэмээн шууд өргөмжилөн алдаршуулсан нь гарцаагүй юм. Энэ үеэс эхлэн түүний дараагийн төрлүүдэд “Жанжаа” гэдэг алдар шууд уламжлагдах хандлагатай болсон.

Жанжаа хутагт Ролбийдорж нь шашны нэрт төлөөлөгч байгаад зогсохгүй улс төрийн нөлөө бүхий зүтгэлтэн байсан юм. Тэнгэрийг Тэтгэгч хаан (1735-1799) Жанжаа хутагт Ролбийдоржийн нэр хүндийг ашиглан Түвдийг засах бодлого явуулж мөн Монгол газар дахь Манж төрийн засаглалаа бэхжүүлэх үйл ажиллагаа хэрэгжүүлж байсан. Тэрээр Далай лам болон Панчен лам нартай ижил түвшинд нэр хүндтэй байж Буддын шашин болон төрийн үйлст хүчин зүтгэж байжээ. Түүний Манж хааны шадар зөвлөх улсын багш байсны үр дүнд Монголын Буддизмыг тухайлан дэмжих, санхүүжүүлэх гэх мэт хойшдын сайн үр дагавартай ажлууд хийгдсэн. Тэрээр Буддын шашныг дэлгэрүүлэх, сүм хийд байгуулах, судар ном орчуулах зэрэг ажлуудыг Манж хааны дэмжлэгтэйгээр амжилттай хэрэгжүүлж байсан. Түүний нэг нь Данжуурын хөлгөн судруудыг Монгол хэлнээ орчуулах ажлыг зохион байгуулсан ба Буддын гүн ухааны орчуулгын онолыг боловсруулсан гавъяатай хүн юмаа гэдгийг бид мэдэх билээ. 1742 онд түүнийг эх сурвалжийг орчуулах арга зүй боловсруулахаас өмнө хэн ч түүн шиг бүтээлийг туурвиж байгаагүй юм. Тухайн үед зайлшгүй тулгарсан улс төрийн нөхцөл байдлаар Манж хааны үйл хэргийн төлөө зүтгэж байсан ч хойч үеийн Монголчууддаа асар үнэтэй бичиг соёлын өв санг үлдээсэн нь Жанжаа хутагт Ролбийдоржийн гайхамшигтай ач гавъяа мөн.

Дүгнэлт: Энэхүү өгүүллийн гол зорилго нь Ролбийдоржийн “Жанжаа хутагт” хэмээх хувилгаан цолны учир шалтгааныг нээн илрүүлэх мөн судлаачдын дунд байдаг ялгаатайтаагаар дугаарлах үзэгдэлд судалгааны үндэслэлтэй хариулт өгч шийдвэрлэх зорилготой байлаа.

Миний ажигласнаар хувилгаан дүрийн лам нарыг дэс тоогоор дугаарлан бичих нь өрнө дахинд Буддын судлал хөгжиж, академик судалгаа хийж эхэлсэнтэй хамт бий болсон судалгааны бичиглэлийн хэв маяг бөгөөд Буддын эх сурвалжууд хувилгаан лам нарыг нэгдүгээр, хоёрдугаар гэх мэтчилэн дугаарлан бичдэг уламжлал бараг байгаагүй юм. Гэхдээ би энэхүү дугаарлах үзэгдлийг буруутгаагүй бөгөөд ижил алдар цолтой түүхэн бие хүмүүсийг хооронд нь дугаараар ялган тэмдэглэх судалгааны оновчтой бичиглэлийн хэлбэр мөн бөгөөд харин судалгааны үндэстэйгээр бичих нь зүйтэй юм. Учир нь аливаа түүхэн бие хүмүүсийн алдар цол бүр өөрийн гэсэн түүхтэй тухайн үг тэмдэглэгээ нь гарал үүсэлтэй тул шууд хариу өгөх боломжгүй юм. Тийм учир шалтгааны дагуу Ролбийдоржийн хувилгаан цолны уг шалтгааныг шинжилж үзэхэд доорхи дүгнэлтийг хийж болохоор байна.

Ролбийдоржийг “Гуравдугаар Жанжаа” гэж нэрлэх нь зөв зүйтэй юм учир нь Жанжаа Дагва-Одсэрээс хойш тодорсон гуравдугаар хувилгаан дүр мөн юм. Судлаачид хэдийгээр “гуравдугаар дүрийн Жанжаа хутагт Ролбийдорж” гэж бичдэг ч энэхүү хувилгаан цолны цаад учир шалтгааны талаар анзаарч байгаагүй байх магадлалтай юм.

Анхны “Жанжаа” болох Дагва-Одсэр нь өөрийн төрсөн тосгоны нэрээр “Жанжаа” хэмээн алдарших болсон. Түүний дараагийн дүр Агваанлувсан нь “Жанжаа” хэмээх алдар цолыг уламжилж авсан шалтгаан нь түүний бага насандаа хэлсэн үг болох “би Жанжаа мөн” хэмээх үг байсан учраас түүнийг “дараагийн Жанжаа” гэдэг утгаар хүлээн зөвшөөрч Дагва-Одсэрийн хойд дүрээр тодруулсан. Агваанлувсан нь Түвд орон төдийгүй Манж, Монголд танигдсан шашин төрийн зүтгэлтэн байсан бөгөөд түүнийг Монголчууд “Жанжаа хутагт” хэмээн хүндэтгэх дуудах болсон. Тиймээс Агваанлувсан нь өөрийн урд дүрийн алдаршсан нэр болох “Жанжаа”-ын ард “хутагт” гэсэн хүндлэлийн тодотголыг нэмсэн гэсэн үг. Түүнээс хойш түүний хойд дүрийн хувилгаан лам нар “Жанжаа хутагт” гэсэн цолоор алдарших уламжлал тогтсон байна.

Жанжаа Дагва-Одсэр

Жанжаа хутагт Агваанлуvsан

Жанжаа хутагт Ролбийдорж

Тиймээс дээрх гурван дүрийн “Жанжаа” лам нараас сүүлийн хоёр нь “хутагт” гэсэн тодотголтой байна. Тиймээс Дагва-Одсэрийг эс тооцон “хутагт” хэмээн өргөмжлөгдснөөр нь Ролбийдоржийг “Хоёрдугаар Жанжаа Хутагт” хэмээн бичих нь буруу юм. Энэ нь ямар нэгэн зэрэг дэвийн мөн дээд тушаалтнаас олгогдсон нэр цолны ялгааны асуудал бус ард олноос өргөмжлөгдсөн нэр цол гэдгээрээ онцлог юм. *Манжийн хаанаас зарим нэгэн дээд лам нарт “хутагт” хэмээх цолыг тусгайлан олгосон тохиолдлууд байдаг боловч Агваанлуvsангийн хувьд энэ утга агуулга тохирохгүй юм.*

Нэмж хэлэхэд анхны “Жанжаа” болох Дагва-Одсэрээс хойш нийтдээ 8 хувилгаан дүр тодорч тэр бүгд “Жанжаа” хэмээн алдарших болсон байна. Наймдугаар Жанжаа Данзандон-Од-Иш (bStan-‘dzin-don-yod-ye-shes) 1980 онд төрж үйл хэргээ явуулж байгаа гэсэн мэдээлэл байна.

ABSTRACT

In this article, I will shed light on whether Rol-pa'i-rdo-rje was the second or the third reincarnation of Changkya Qutuytu, and what is the underlying meaning of the “title”. Some researchers claim that Rol-pa'i-rdo-rje was second reincarnation, yet some claim that he was the third reincarnation. Thus, researchers have not reached at the same position regarding Rol-pa'i-rdo-rje's title and his reincarnation rank. I assume that distinguishing reincarnate lamas by adding ordinal numbers is a result of research works after nineteenth century. Buddhist high lamas possess multiple names and titles with own stories. All arguments regarding titles should be discussed along with derivation of word, historical background and other incidents. Three Changkyas are branches of the same incarnation lineage. Changkya Grags-pa-'od-zer could not become popular among Mongolians and Manchu officials; therefore, he could not get an extension to his title “Qutuytu”. Grags-pa-'od-zer was recognized with the toponym-title “Changkya”, and his successors preserved his title putting another extension “Qutuytu”. However, according to the contemporary fashion of research, Rol-pa'i-rdo-rje is the third Changkya due to the title without extension.²⁰

НОМ ЗҮЙ

1. dKon-mchog-'jigs-med-dbang-po. rJe btsun bla ma thams cad mkhyen pa lchang skya rol pa'i rdo rje'i 'khrungs rab(s) kyi phreng ba gтам du brjod pa ngo mtshar dad pa'i ljon shing zhes bya ba.
2. Introduction to Altaic Philology. Edited by Igor Rachewitz and Volker Rybatzki with the collaboration of Hung Chin-fu, Boston: Brill Leiden., 2010.
3. *ICang-skya Rol-pa'i-rdo-rje. Dag yig mkhas pa'i 'byung gnas*, Цбүр Mongγol-un arad-un keblel-ын qoriy-a., 2002.
4. *ICang-skya Rol-pa'i-rdo-rje. Dag yig mkhas pa'i 'byung gnas. [Буруад бар]*
5. Namjil. Ki. Mongγol Buddha-yin šasin-u udq-a jokiyal-un sudulul. Цбүр Mongγol-un arad-un keblel-ын qoriy-a., 2015.
6. Obermiller. Dr.E. History of Buddhism by Bu-ston. Heidelberg: Harrassowitz, Leipzig., 1931.
7. Roerich George. Blue annals by Gzhon nu dpal. New Delhi: Motilal Banarsidass., 1979.

²⁰ Sainbileg Byambadorj. *A Philological study on the Dag-yig-mkhas-pa'i-'byung-gnas*. Republic of Korea: The Academy of Korean Studies., 2016. (dissertation)

8. Sainbileg Byambadorj. A Philological study on the Dag-yig-mkhas-pa'i-'byung-gnas. Republic of Korea: The Academy of Korean Studies., 2016 (Dissertation).
9. Sarat Chandra Das. Pag sam jon zang. Calcutta: The presidency jail press., 1908.
10. Sarat Chandra Das. Tibetan English Dictionary (with Sanskrit synonyms). Delhi: Motilal Banarsidass., 1979.
11. Smith, E. Gene. The Life of Lcang skya Rol pa'i rdo rje: Among Tibetan Texts. History and Literature of the Himalayan Plateau. Edited by Kurtis, R. Schaeffer, Somerville: Wisdom Publications., 2001 pp 133–146.
12. Сымбе قامбо Isibaljor-un burqan-u šasin-u тэке. Цэцр Mongγol-un arad-un keblel-ын qoriy-a., 1993.
13. Sun, Penghao, Shi Yangang, and Hasichaolu. “The 1780 Quadrilingual Inscriptions in the Longxing Monastery: The Texts and Background.” In Xiyu lishi yuyan yanjiu jikan 西域歷史語言研究集刊 (No.8) edited by Shen Weirong, 523-34. Beijing: Science Press., 2015.
14. *Tu'u-bkwan blo-bzang-chos-kyi-nyi-ma. lcang skya rol pa'i rdo rje'i rnam thar.*
15. Xiangyun Wang. The Qing Court's Tibet Connection: Lcang skya Rol pa'i rdo rje and Qianlong Emperor. Harvard Journal for Asiatic Studies, Vol. 60, No. 1 (Jun., 2000), pp. 125-163.
16. Зава Дамдин Лувсандаян. *Алтан дэвтэр* (орчуулсан С. Гантөмөр). УБ: МБШТөв Гандантэгчилэн хийдийн Эрдэм Соёлын Хүрээлэн., 2014.
17. Монголын философийн түүх, I-III дэвтэр. УБ., 2000.
18. Пубаева.Р.Е. *Пагсам Джонсан: История и хронология Тибета*. Новосибирск: Наука, Сибирское отделение., 1991.
19. Рерих [Ю. Н]. Төвд хэлэнд орсон монгол үг, Олон улсын монгол хэл бичгийн эрдэмтний анхдугаар их хурал., 2-дэвтэр, УБ: ШУАХ, 1961.
20. Ц.Дамдинсүрэн. Монгол хэлэнд орсон төвд үгс, Олон улсын монгол хэл бичгийн эрдэмтний анхдугаар их хурал., 1-дэвтэр, УБ: ШУАХ, 1961.
21. Я.Цэвэл. *Монгол хэлний товч тайлбар толь*. УБ., 1963.